

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



АУДИТЫН НЭР: ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

АУДИТЫН КОД: УАГ-НАГ-/2019/01-НА

ШИЛЭН ДАНС

ТӨСВИЙН ЕРӨНХӨЙЛӨН ЗАХИРАГЧ | ЯАМ | АГЕНТЛАГ | ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙ НЭГЖ | ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР | АЖ АХУЙ НЭГЖ, ТӨРИЙН БҮС БАЙГУУЛЛАГА, ИРГЭН

Дэлгэрэнгүй хайлт | Татан буулдсан байгууллагууд

Эхлэл | Орон нутаг | Мэдээ мэдээлэл | Холбоо барих | Нэвтрэх

БАЯНХОНГОР

Баянхонгор аймаг-Сум

Баянхонгор сум

Баацагаан сум

Баянбулаг сум

Баянговь сум

Баянхил сум

Баян-Овоо сум

Баян-Өндөр сум

Баянцагаан сум

Улаанбаатар | Баян-өлгий | **Баянхонгор** | Булган | Говь-алтай | Архангай

Говьсүмбэр | Дархан-уул | Дорноговь | Дорнод | Дундговь | Хэнтий

Завхан | Орхон | Өвөрхангай | Өмнөговь | Сүхбаатар | Хөвсгөл

Сэлэнгэ | Төв | Увс | Ховд

Шилэн дансны нэгдсэн цэстэд байршуулсан мэдээллийн агуулга, чанар хангалтгүй байна.

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:
Баянхонгор аймаг дахь
Төрийн Аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор
Б.Мөнхбат
Аудитын менежер
Д.Цэцэгмаа
Ахлах аудитор
Б.Должмаа
Аудитор
П.Мөнх-Эрдэнэ
Г.Ганчимэг

2019 оны 04 дүгээр сарын 08

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70442584, 70442424
дугаарын утсаар харилцана
уу.

ХАЯГ: Баянхонгор аймаг
дахь Төрийн аудитын газар

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2
НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН.....	3
НИЙЦЛИЙН АУДИТЫН ДҮН	7
1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 хамаарах байгууллагууд шилэн ансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдаж, мэдээллийн 90.9 хувийг хугацаанд нь байршуулжээ.	7
1.1. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 6.1-д заасан мэдээллийн 87.5 хувь, 6.4-д заасан мэдээллийн 94.3 хувийг хугацаанд нь байршуулжээ.....	7
1.2. Шилэн дансны мэдээллээ байгууллагууд мэдээллийн самбарт хуульд заасан шаардлагын дагуу бүрэн байршуулсан байна.....	12
2. Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-3.1.5-т хамаарах аж ахуйн нэгж, байгууллагууд цахим хуудаст мэдээллийг тухай бүр бүрэн байршуулаагүй байна.....	13
2.1. Хуулийн 3.1.3-т хамрагдах байгууллагууд хуульд заасан мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.....	13
2.2. Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-т хамаарах аж ахуйн нэгж, байгууллагуудын хувьд дараа жил нь үйл ажиллагаа явуулах эсэх нь тодорхойгүй байхад цахим хуудаст шинээр цэс нээж мэдээлүүлэх нь хуулийн энэ заалт хэрэгжих боломжгүй байна.....	13
2.3. Төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна.....	14
3. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дах хэсэгт заасан байгууллага, албан тушаалтнууд мэдээллийг нарийвчлан хянаж үзээгүй байна.....	15
3.1. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд сумын ИТХ хяналт тавьж ажилласан байна.....	15
3.2. Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. 17	
Холбогдох байгууллагын санал.....	20
АУДИТЫН ДҮГНЭЛТ.....	22
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ.....	23
Тайлан баталгаажуулсан тушаал.....	24-25
Хавсралт судалгааны маягт.....	26-58

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ҮАГ	Үндэсний аудитын газар
НАГ	Нийцлийн аудитын газар
НА	Нийцлийн аудит
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
ТӨЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ТШЗ	Төсвийн шууд захирагч

Хавсралт маягтын жагсаалт

Маягт №1	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газар "тогтсон хугацаа"-д мэдээлэл байршуулах тайлангийн маягт
Маягт №2	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газар "долоо хоног"-ийн дотор мэдээлэл байршуулах тайлангийн маягт
Маягт №3	Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компанийн мэдээлэл тайлагнах маягт
Маягт №4	Улс, орон нутгийн төсөв, засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, засгийн газар түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаагаар санхүүжиж байгаа төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээг арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллагын мэдээлэл
Маягт №5	Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчийн мэдээлэл
Маягт № 6	2018 оны 04 дүгээр улирлын байдлаар гарсан алдаа, зөрчлийн нэгтгэл

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтыг үндэслэн УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2018 оны 01 тоот тогтоол, ҮАГ-ын 2019 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, аудитын дүнг УИХ-д танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Дээрх зорилтын хүрээнд дараах чиглэлийн дагуу аудитыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1¹, 3.1.2²-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх;
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3³, 3.1.4⁴, 3.1.5⁵-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн эсэх;
- Хуулийн 8 дугаар зүйлд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг биелүүлсэн эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.5-д заасан хуулийн этгээд, төрийн байгууллагыг түүвэрт хамруулж, 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийг хүртэлх хугацааны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгав.

¹ “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд”

² “төрийн өмчит үйлдвэрийн газар”

³ “хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани”

⁴ “улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага”

⁵ “төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч”

Үндсэн мэдээлэл

Баянхонгор аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төрийн өмчит **23**, орон нутгийн өмчит **187** байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж **4**, төрийн өмчит үйлдвэрийн газар **2**, 3.1.3-т хамаарах орон нутгийн өмчит **3** аж ахуйн нэгж, 3.1.5-т хамаарах аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан ажиллаж буй **15** байгууллага, аж ахуйн нэгж, **нийт 234** байгууллага, аж ахуйн нэгж шилэн дансны нэгдсэн портал системд бүрэн хамрагдсан байна.

Өмнөх оны аудитаар татан буугдсан Заг сумын эмийн эргэлтийн сан, Орог нуур-Түйн голын сав газрын захиргаа гэсэн байгууллагыг шилэн дансны нэгдсэн цахим хуудсаас хасаагүй, 4 байгууллагын өмчийн хэлбэрийг буруу бүртгэсэн зөрчил илэрснийг арилгасан байна.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-т хамаарах компаниуд мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн ба улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэгч ААН, байгууллагуудаас “Шанхай констракшн” ХХК-аас бусад ААН-үүд шилэн дансанд мэдээллээ байршуулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-т хамаарах аж ахуйн нэгж, байгууллагуудын хувьд дараа жил нь үйл ажиллагаа явуулах эсэх нь тодорхойгүй байхад цахим хуудаст шинээр цэс нээж мэдээлүүлэх нь хуулийн энэ заалт хэрэгжих боломжгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.5-т заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх заалтыг зөрчиж, цахим хуудсанд ажил үйлчилгээг гүйцэтгэхэд гарсан зардлыг шилэн дансанд мэдээлээгүй байна.

Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө хөтөлбөрийн асуудлын шинжилгээнээс 1 дүгээр зорилтын 3 дахь асуудал орон нутгийн түвшинд хамааралгүй байна.

Сангийн яамнаас Төсвийн ерөнхийлөн захирагч нарын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 2017 оны эхний хагас жилийн байдлаар шалгахад 37 байгууллага тайлан илгээгээгүй бөгөөд шилэн дансны тайлагналт 23% -тай үнэлэгдсэн байна. Аймгийн ТЕЗ тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд 2017 оны жилийн эцсийн байдлаар мэдээллийг 96.3%-тай мэдээлж, тайланг 77.7%-

тай илгээж, хэрэгжилт дунджаар 87%-тай үнэлэгдсэн байна. 2018 оны байдлаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг үнэлсэн нэгдсэн дүн гараагүй байна.

Аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчит 199 байгууллагыг хамруулан 2017 оны 4-р улирал, 2018 оны 1, 4 дүгээр улирлын байдлаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод хяналт шалгалт хийж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтан, аймгийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын хорооны хуралд танилцуулан ажилласан боловч мэдээллийн үнэн зөв байдалд тавих хяналт хангалтгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2018 оны 10 дугаар сард хийсэн нийцлийн аудитаар нийт 8 зөвлөмж өгснийг 76,3 хувьтай хэрэгжүүлж ажиллажээ.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100-400, 4000, 4100 дугаар стандартууд болон Төрийн хяналт, шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан хууль хэрэгжүүлэгч байгууллага, аж ахуйн нэгжийн мэдээллийн самбар болон цахим хуудаст байршуулсан мэдээллийг дансны хуулгын дүн, анхан шатны баримт, журналтай тулгаж, дүн шинжилгээ хийж, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулан аудитын арга зүйг ашиглан, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд

Дараах хууль эрхийн актуудыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- ✓ Монгол Улсын Үндсэн хууль
- ✓ Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- ✓ Төрийн аудитын тухай хууль
- ✓ Шилэн дансны тухай хууль
- ✓ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- ✓ Монгол улсын 2017 оны төсвийн тухай хууль
- ✓ Монгол улсын 2017 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- ✓ Засгийн газрын 2016 оны 01 дугаар сарын 11-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”
- ✓ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”
- ✓ Бусад холбогдох хууль, дүрэм, журам

Хүндрэл бэрхшээл

Шилэн дансны мэдээллийг хянах эрхээр орж нэгтгэлийг авч үзэхэд “Хавсралт дээр тохиргоо хийгдээгүй байна. Нэгдсэн админд хандаж тохиргоо хийлгэнэ үү” гэж системээс мессеж өгч алдаа гарч байсан ба аудитын хавсралт судалгааны маягтыг бөглөхөд заавал тухайн байгууллага руу энгийн хандалтаар хандаж нарийвчлан үзэх шаардлага үүсч байгаа нь цаг хугацаа ихээхэн шаардагдсан болно. Мөн Шилэн дансны цахим хуудсанд тавьсан мэдээллийг үзэхэд төвөгтэй, хэвлэж авах боломжгүй, байршуулсан мэдээллийн гүйлгээний тоог нийт дүнгээр татахгүй сарын тоогоор татдаг, тухайн цэсэнд хэдэн хүн нэвтэрч мэдээлэл үзсэнийг харах боломжгүй байгааг цаашид анхаарч, системд шинэчлэлт хийж хөгжүүлэх шаардлагатай байна.

НИЙЦЛИЙН АУДИТЫН ДҮН


Бүлэг 1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх?

1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 хамаарах байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдаж, мэдээллийн 90.9 хувийг хугацаанд нь байршуулжээ.

1.1. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 6.1-д заасан мэдээллийн 87.5 хувь, 6.4-д заасан мэдээллийн 94.3 хувийг хугацаанд нь байршуулжээ.

Баянхонгор аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.2 дахь заалтад хамаарах төрийн болон орон нутгийн өмчит **209** байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж **4**, төрийн өмчит үйлдвэрийн газар **2**, **нийт 215** төсвийн байгууллага, аж ахуйн нэгж шилэн дансны нэгдсэн портал системд бүрэн хамрагджээ.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 -т хамаарах байгууллагуудыг эзлэх хувийн жингээр харуулбал:



"ТОГТСОН ХУГАЦАА"-нд цахим хуудас, мэдээллийн самбараар тайлагнах мэдээллийн төрөл тус бүрээр нь авч үзвэл:

Шилэн дансны тухай хуулийн заалт		Байгууллагын тоо	Тухайн мэдээлэл хамааралгүй	Мэдээл бэл зохих	Үүнээс		
					Хугацаандаа мэдээлсэн	Хугацаа хоцорсон	Мэдээлээгүй
1		2	3	4	5	6	7
6.1.1	Тухайн жилийн төсөв	215	7	208	171	28	9
	ОНХС-ийн төлөвлөгөө	215	194	21	19	2	-
	ХАА-ны төлөвлөгөө	215	29	186	162	17	7

	1	2	3	4	5	6	7
6.1.2	Төсвийн гүйцэтгэл	215	4	3005	2702	274	29
6.1.3	Дараа жилийн төсвийн төсөл	215	4	211	149	1	61
6.1.4	Санхүүгийн тайлан /хагас жил/	215	4	211	180	6	25
	Санхүүгийн тайлан /Жилийн эцсийн /	215	6	209	195	1	13
6.1.5	ТЕЗ-ын төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлт	215	6	209	188	1	20
	Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	215	59	156	99	15	42
6.1.6	Төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	215	11	204	177	7	20
НИЙТ ДҮН			324	4620	4042	352	226

Аудитаар ТЕЗ-ийн дүнгээр хуулийн 3.1.1, 3.1.2-д хамаарах байгууллагууд хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д хамаарах мэдээлбэл зохих нийт 4620 мэдээллээс 87,5%-ийг буюу 4042 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 352 мэдээллийг хугацаа хоцроож, 226 мэдээллийг байршуулаагүй байна.Үүнд:

-6.1.1-д заасан тухайн жилийн төсөв, ОНХС-ийн төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 16 байгууллага буюу 8,6 хувь нь мэдээлээгүй;

-6.1.2-т заасан төсвийн гүйцэтгэлийг мэдээлбэл зохих 3005 мэдээллээс хугацаанд нь 2702 хугацаа хоцроож 274 мэдээллийг мэдээлсэн ба нийт 99 хувьтай байршуулсан байгаа нь өмнөх оны аудитын дүнгээс 1,7 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна.

-6.1.3-т заасан дараа жилийн төсвийн төслийг 61 байгууллага буюу 29 хувь нь мэдээлээгүй;

-6.1.4-т заасан хагас жилийн санхүүгийн тайланг 25 байгууллага буюу 11,8 хувь, бүтэн жилийн санхүүгийн тайланг 13 байгууллага буюу 6,2 хувь нь мэдээлээгүй;

-6.1.5-т заасан ТЕЗ-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 20 байгууллага буюу 9,5 хувь, аудитын дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 42 байгууллага буюу 26,9 хувь нь мэдээлээгүй;

-6.1.6-т заасан төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгаан тайлбарыг 20 байгууллага буюу 9,8 хувь нь тус тус мэдээлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.6⁶-д заасны дагуу Сум хөгжүүлэх сангийн сонгон шалгаруулалтын талаарх мэдээллийг иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй хүргээгүй, иргэдэд олгосон хөнгөлөлттэй зээлийг “төсөв ба гүйцэтгэл” болон “худалдан авалт” цэсэнд давхар мэдээлсэн байна.

Тухайн мэдээлэл гарснаас хойш “ДОЛОО ХОНОГ”-ийн дотор мэдээллийг байршуулсан эсэхийг шалгахад дараах байдалтай байна.

Шилэн дансны тухай хуулийн заалт	Хамааралгүй	Мэдээлбэл зохио	Мэдээлсэн	Мэдээлээгүй
6.4.1. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	41	174	174	0
6.4.2. Тухайн байгууллагын төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт	151	64	64	0
6.4.3 Тендер, худалдан авалттай холбоотой мэдээлэл	63	152	152	0
6.4.6. Худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	213	2	2	0
6.4.7. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	214	1	1	0
Нийт дүн	682	393	393	0

Аудитад хамрагдсан 215 байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн 6.4⁷ дэх заалтад хамаарах мэдээлбэл зохио 11162 мэдээллээс 94,3 хувь буюу 10529 мэдээллийг цахим хуудсанд байршуулжээ.

Хуулийн 6.4.1⁸, 6.4.2⁹, 6.4.3¹⁰ дахь заалтын дагуу 3 байгууллагаас бусад байгууллагууд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

⁶ “хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл;”

⁷ “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”

⁸ “тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт”

⁹ “тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт”


¹⁰ “тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан”

Шилэн дансны тухай хуулийн 6.4.4¹¹, 6.4.5¹² дахь заалттай холбоотой 156998,6 сая төгрөгийн 4517 гүйлгээнээс 8485,6 сая төгрөгийн 443 гүйлгээг давхардсан тоогоор нийт 140 байгууллага мэдээлээгүй, мөн хуулийн 6.4.8¹³-д заасан төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 23087,4 сая төгрөгийн 5619 шийдвэрээс 274,1 сая төгрөгийн 190 шийдвэрийг мэдээлээгүй байна.

Иймд төрийн болон орон нутгийн өмчит төсвийн байгууллагуудаар шилэн дансанд мэдээллийг нөхөн байршуулж, хэрэгжилтийг тооцож ирүүлэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд шилэн дансанд байршуулах нийт 305 мэдээллээс 221 мэдээлэл байршуулж, 84 мэдээлэл буюу 27,5 хувийг мэдээлээгүй зөрчил /өмнөх оны аудитаар гэж тодруулж өгөх үү/ илэрсэн тул нөхөн мэдээлэх албан шаардлагыг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлж зөрчлийг арилгуулав. Тухайлбал:

- “Хот тохижилт” ОНӨТҮГ хуулийн 6.4.5, 6.4.8-д хамаарах 35,2 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй;
- “Хонгор шинэ агро” ОНӨААТҮГ хуулийн 6.4.5, 6.4.8-д хамаарах 68,5 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй;
- “Баянхонгор хайрхан фарм” ОНӨААТҮГ хуулийн 6.4.4, 6.4.5, 6.4.8-д хамаарах 651,3 сая төгрөгийн гүйлгээ, 11 шийдвэрийг мэдээлээгүй.



¹¹ “тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”

¹² “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”


¹³ “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”

Хуульд заасны дагуу 7 хоногт мэдээлэх мэдээллийг харуулбал:

/Сая төгрөгөөр/

Мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх мэдээлэл	Нийт		Үүнээс: мэдээлээгүй	
	тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн
6.4.4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл	839	45896.6	83	622.7
6.4.5. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	1191	22653.7	148	1939.1
6.4.5. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	2487	88448.3	212	5923.8
6.4.8 Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл	5474	18074.7	190	274.1
Нийт	9991	175073.3	633	8759.7

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д хамаарах байгууллагуудын мэдээлэл байршуулсан байдлыг өмнөх онуудын аудитын дүнтэй харьцуулбал:



Аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны мэдээллийг байршуулах төлөвлөгөөг аймгийн СТСХ-ийн дарга 2017 оны 09 дүгээр сард шилэн дансны үндсэн 3-н цэсийг ажил үүргийн хуваарьтай нь уялдуулж төлөвлөгөө гаргажээ.

Хуваарийн дагуу мэдээлэл байршуулсан байдлыг шалгахад мэдээлэх үүрэг хүлээсэн албан тушаалтнууд Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт цэсний нийт мэдээллийн 32,5 хувийг, төсөв, гүйцэтгэл цэсний 40,6 хувийг, бусад цэсний 33,3 хувийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Өмнөх оны аудитаар шилэн дансанд байршуулахдаа мэдээллийг сайтар хянаж, хуулийн хугацаанд нь иж бүрэн, үнэн зөв мэдээлж байх зөвлөмжийг аймгийн

Засаг даргад хүргүүлж ажилласны үр дүнд аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны мэдээллийг байршуулах ажилд ахиц гарсан байна.

Шилэн дансны нэгдсэн системд байгууллагын тодруулга өгөх албан тушаалтны нэр, утсыг шинэчлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3¹⁴, 5.1.4¹⁵ дэх заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”-ын 2.2.15¹⁶-т зааснаар төсөв, төрийн сангийн мэргэжилтэн шилэн дансны тухай хуулийг хэрэгжилтийг хангаж ажиллахаар байна. Иймд цаашид дээрх зааврын дагуу ажлын төлөвлөгөөг удирдлагаар батлуулж, мэдээллийн агуулга, чанарт хяналт тавьж ажиллахыг зөвлөмж болгов.

1.2. Шилэн дансны мэдээллээ байгууллагууд мэдээллийн самбарт хуульд заасан шаардлагын дагуу бүрэн байршуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 5.7-д “Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна” гэж заажээ.

Өмнөх онд гүйцэтгэсэн нийцлийн аудитаар түүврийн аргыг ашиглан Баянхонгор сумын 24 байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан мэдээллийг шалгахад 7 байгууллага олон нийт мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломжийг бүрдүүлээгүй, байршуулсан мэдээлэл нь ач холбогдлоо алдсан, тогтоосон хугацаанд нь шуурхай, иж бүрэн, үнэн зөв мэдээлээгүй Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1¹⁷-дэх заалтыг зөрчсөн зөрчилд удирдлага арга зүйгээр хангаж ажиллах зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлсний дагуу байгууллагууд зөрчлийг арилгаж ажилласан байна.

¹⁴ “тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийг байршуулсан байх;”

¹⁵ “мэдээллийг тогтмол шинэчилж байх, өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийг цахим хуудасны архивт хадгалах, архивын мэдээллийн санд нэвтрэх, татаж авах, хэвлэх боломжтой байх.”

¹⁶ “Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг удирдлагаар батлуулах.”

¹⁷ “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”

Бүлэг 2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн эсэх?

2. Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-3.1.5-т хамаарах аж ахуйн нэгж, байгууллагууд цахим хуудаст мэдээллийг тухай бүр бүрэн байршуулаагүй байна.

2.1. Хуулийн 3.1.3-т хамрагдах байгууллагууд хуульд заасан мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-т хамаарах “Баянхонгор эрчим хүч” ЦТХХК нь 249,0 сая төгрөгийн 4 тендерийг мэдээлсэн ба харин “Чандмань Баянхонгор” ХК, “Нью майнинг” ХХК-ууд нь 2018 оны 4 дүгээр улирлын байдлаар хуулийн 6.8.2¹⁸-т заасан худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

“Баянхонгор эрчим хүч” ЦТХХК болон “Чандмань Баянхонгор” ХК нь Шилэн дансны тухай хуулийн 6.8.1¹⁹-д хамаарах 2808,1 сая төгрөгийн 96 шийдвэрийг шилэн дансны цахим хуудаст байршуулжээ.

2.2. Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-т хамаарах аж ахуйн нэгж, байгууллагуудын хувьд дараа жил нь үйл ажиллагаа явуулах эсэх нь тодорхойгүй байхад цахим хуудаст шинээр цэс нээж мэдээлүүлэх нь хуулийн энэ заалт хэрэгжих боломжгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4²⁰ -т хамаарах байгууллагууд хуулийн 6 дугаар зүйлийн 6.9²¹ дэх заалтад заасны дагуу гэрээний үндсэн дээр улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 10,0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил,

¹⁸ “худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан”

¹⁹ “тухайн байгууллагад холбогдох энэ хуулийн 3.2.5, 3.2.7, 3.2.8-д заасан шийдвэр”

²⁰ “3.1. Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна: 3.1.4. улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага;”

²¹ “Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй.”

үйлчилгээг “Шанхай Констракшн групп” ХХК-аас бусад аж ахуйн нэгжүүд цахим хуудсанд цэс үүсгэж, мэдээллийг байршуулаагүй байгаа нь нэг удаа тендерт шалгарч ажил гүйцэтгэсэн аж ахуйн нэгж шилэн дансны цахим хуудсанд цэс үүсгэж дараа нь мэдээлэл байршуулах шаардлага гарахгүйгээс системд ашиглагдахгүй цэстүүд байрших нь хуулийн холбогдох заалт хэрэгжих боломжгүйг харуулж байна.

Иймээс цаашид хуулийн 3.1.4-т хамаарах аж ахуйн нэгжүүдийн шилэн дансанд байршуулах мэдээллийг энэхүү заалтын хэрэгжилтийг хангах үүднээс аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны цахим хуудсанд батлагдсан маягтаар улирал бүр нэгтгэж, бүрэн мэдээлж байх зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын СТСХэлтэст хүргүүлэв.

2.3. Төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5²²-т заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд аймгийн ТЕЗ-ийн цахим хуудсанд аймгийн СТСХ-ээр дамжуулан мэдээллийг байршуулж байсан бөгөөд 2018 оны 02 дугаар сараас эхлэн байгууллагын нэрээр цахим хуудсанд цэс нээж, Засгийн газрын 2016 оны 29 тоот тогтоолоор баталсан журмын 19 дүгээр хавсралтын дагуу улирал тутам мэдээллийг оруулж байгаа хэдий ч дараах зөрчилтэй байна. Аудитаар илэрсэн зөрчлийг ААН-ээр харуулбал:

№	Байгууллагын нэр	Зөрчлийн утга	Зөрчлийн мөнгөн дүн
1	“Хүүхэд хөгжлийн Тэмүүлэл төв” ТББ	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх заалтыг зөрчиж, цахим хуудсанд санхүүжилт болон ажил үйлчилгээг гүйцэтгэхэд гаргасан зардлыг мэдээлээгүй.	28.1
2	“Сод баян элбэг” ХХК		22.4
3	“Хүүхдийн сургалт хүмүүжлийн Тэргэл төв” ТББ		109.1
4	“Эх шовон” ХХК		19.5
5	“Ханбаянхонгор” ХХК		52.2
6	“Гэгээнхэн гэрэл” ХХК		12.4
	Дүн		243.7

Иймд ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээнд гүйцэтгэгчийн шилэн дансанд мэдээлэх үүрэг, хариуцлагын талаар тусгах, хэрэгжилтэд хяналт тавих байгууллага, албан тушаалтан болон хүлээлгэх хариуцлагыг “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга нийтлэг стандартыг тогтоох журам”-д тодорхой тусгах шаардлагатай байна.

²² " төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч."

Бүлэг 3. Хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх?

3. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дах хэсэгт заасан байгууллага, албан тушаалтнууд мэдээллийг нарийвчлан хянаж үзээгүй байна.

3.1. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд сумын ИТХ хяналт тавьж ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1²³-т заасны дагуу бүх шатны ИТХ, ИНХ нь хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд аймгийн ИТХ-ын 2018 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 16/491 тоот албан бичгээр ирүүлсэн тайлангаас үзэхэд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн дунд сургалт явуулж, хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тогтоол гаргаж, түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан гэх боловч алдаа зөрчил бүрэн арилахгүй байна.

Баянхонгор сумын 3, 7 дугаар багийн ИНХ-ын дарга нартай ярилцлага хийхэд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ойлголтгүй, хийж хэрэгжүүлсэн ажил байхгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2²⁴-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2017 оны 4-р улирал болон 2018 оны 1,4-р улирлын байдлаар хуулийн 3 дугаар зүйлийн 3.1²⁵-д заасан орон нутгийн өмчит 199 байгууллагыг хяналт шалгалтад хамруулжээ.

Тус хяналт шалгалтаар байгууллагууд нь мэдээллийг хугацаанд нь оруулсан ч дутуу хоосон хадгалдаг, аливаа шийдвэрийн хавсралт файлыг оруулдаггүй, улирлын тайланг илгээсэн ч шилэн дансны мэдээллийг нэр төдий оруулдаг зэрэг зөрчлүүд илэрсэн ба хяналт шалгалтын хугацаанд зөрчлийг арилгуулж, шалгалтын дүнг аймгийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын хороонд танилцуулж, гарсан шийдвэрийг холбогдох байгууллагуудад хүргүүлж ажиллажээ.

²³ " Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ."

²⁴ " Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ."

²⁵ " Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна."

Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан журмын 8.1²⁶-д заасны дагуу ТЕЗ-ийн харьяаны байгууллагууд тайлангаа улирал бүр ирүүлдэг эсэх талаар аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны даргаас тодруулахад хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд улирлын тайлангаа ирүүлдэггүй бөгөөд үүнтэй холбоотой зөвлөмжийг 2017 оны эцэст хүргүүлсэн гэсэн тайлбарыг өгсөн.

Аудитаар Санхүүгийн хяналт аудитын алба нь Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8.2²⁷-т заасны дагуу ТЕЗ-ийн 2018 оны 2 улирлын шилэн дансны тайланд хяналт шалгалт хийж холбогдох байгууллагад хүргүүлээгүй зөрчил илэрсэнд хууль, журмын дагуу тайланг хянаж, нэгтгэж, холбогдох газарт хүргүүлж ажиллах, мөн ТЕЗ-ийн харьяаны байгууллагуудын улирлын тайланг хугацаанд нь бүрэн ирүүлэх талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож ажиллах зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан байна. Гэвч байгууллагуудад дараахь нийтлэг зөрчил байна.

- *Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т заасан тендер худалдан авалтын мэдээлэлд ажиллагсдад олгосон тэтгэмж, нийгмийн даатгалын сангийн жирэмсэн амаржсаны тэтгэмж, санхүүжилт, наадмын зардал, нийгмийн даатгалд шилжүүлсэн шимтгэлийн зардал зэрэг хамааралгүй мэдээллийг мэдээлсэн /Эрдэнэцогт сумын Сургууль, Номундалай цогцолбор сургууль, Баян-Ойт бага сургууль гэх мэт/*
- *Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-т санхүүжилтийг өссөн дүнгээр мэдээлсэн /БОАЖГазар, 6 дугаар Цэцэрлэг, 5 дугаар Цэцэрлэг гэх мэт/*
- *Худалдан авалтын мэдээлэлд гэрээний дүнг бичээгүй /7, 11 дүгээр цэцэрлэг, Баянлиг сумын ЗДТГ, Баянбулаг сумын цэцэрлэг гэх мэт/*
- *Өмнөх саруудад оруулсан мэдээллийн дүнгийн нийлбэрийг тухайн сарын мэдээнд оруулж мэдээлсэн; /5 дугаар Цэцэрлэг, Баянцагаан сумын Цэцэрлэг гэх мэт/*
- *Мөнгөн дүнг алдаатай оруулснаас сая төгрөгөөр илэрхийлэгдэх дүнг тэрбум төгрөгөөр буруу илэрхийлсэн, мэдээллийн өгөгдлийг гүйцэд оруулаагүй /Баянхонгор аймгийн ЗДТГ, Баянлиг сумын Засаг дарга, 13 дугаар Цэцэрлэг гэх мэт/*
- *Зарим байгууллага нэг төрлийн мэдээллийг нэг дор хоёр удаа мэдээлсэн /Баян-Овоо сумын Засаг дарга/*
- *Худалдан авалт дээр мэдээлсэн мэдээллийг хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь хэсэгт хамааруулан давхардуулж мэдээлсэн /Номундалай цогцолбор сургууль,*

²⁶ “ Шилэн дансанд мэдээлэл тавьсан албан тушаалтан, тухайн асуудал хариуцсан нэгж нь байршуулсан мэдээллээ улирал бүр ТЕЗ-ийн дотоод аудитын албанд дараа сарын 15-ны дотор тайлагнана.”

²⁷ “Дотоод аудитын алба нь улирлын нэгдсэн тайланг санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа сарын 25-ны дотор хүргүүлнэ..”

аймгийн МХГ гэх мэт/, орон тооны мэдээлэл оруулсан /Нийгмийн даатгалын хэлтэс/ зэрэг зөрчилтэй байна.

Иймд цаашид хуулийн 8 дугаар зүйлд заасан байгууллагууд болон аймгийн Засаг даргын захирамжаар төсөвт байгууллагуудын шилэн дансны мэдээлэлд хяналт тавьж байгаа CTCX-ийн мэргэжилтнүүд дээрх алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч, нягтлан бодогчдыг нэгдсэн арга зүйгээр хангаж ажиллах шаардлагатай байна.

3.2. Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2018 оны 3 дугаар улиралд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар хийсэн аудитаар аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга болон CTCX, Санхүүгийн хяналт аудитын албанд нийт 8 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлжээ.

Өмнөх оны аудитын зөвлөмжийн биелэлтийг тооцож үзэхэд 5 зөвлөмжийг бүрэн, 3 зөвлөмжийг 30-50 хувьтай биелүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 76,3 хувьтай байна.

Зөвлөмж тус бүрийн биелэлтийг дүгнэсэн байдал:

№	Өгсөн зөвлөмж	Байгууллагаас ирүүлсэн хариу	Аудитаар тооцсон биелэлт
Аймгийн ИТХ-ын дарга Ц.Отгонбаярт			
1	Бүх шатны ИТХ хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлсэн тайланг нэгтгэн дүгнэж, энэ талаар гаргасан шийдвэрийн хэрэгжилтийн үр дүнг тооцож ажиллах.	Сумдын ИТХ-аас томилогдсон ажлын хэсэг шилэн дансны мэдээлэлд хяналт тавьж ажилласан ба 11 сумын ИТХ-ын ажлын албанаас байгууллага, иргэдийн дунд сургалт явуулж, хуулийг сурталчилж ажилласан.	Зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна. Биелэлт 100 хувь.
Аймгийн Засаг дарга Г.Батжаргалд			
1	Төрийн болон орон нутгийн өмчит төсвийн байгууллагуудаар шилэн дансанд мэдээллийг нөхөн байршуулж, хэрэгжилтийг тооцож ирүүлэх.	Аймгийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 28-ны 1а/1066 дугаар албан бичгээр Санхүүгийн хяналт, аудитын алба болон сумдын Засаг дарга, төсвийн захирагч нарт "Шилэн дансны тухай" хуулийн хэрэгжилтийг сайжруулах, хяналт тавьж, хэрэгжилтийг тооцож ажиллах тухай чиглэлийг хүргүүлсэнээр мэдээллийг нөхөн байршуулсан. Аймгийн Засаг даргын 127 тоот захирамжаар батлагдсан журамд заасны дагуу хяналт тавьж, тайланг ирүүлж байхыг сумдын Санхүүгийн албаны дарга нарт мэдэгдсэн.	Мэдээллийг дутуу байршуулсан байгууллагууд шилэн дансанд нөхөн мэдээлсэн байна. Шилэн дансны хяналт хийсэн тухай тайланг Сумдын санхүүгийн албадаас ирүүлээгүй байна. Биелэлт 50 хувь.
2	Аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны мэдээллийг Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн	Аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны мэдээллийг тогтсон хугацаанд нь иж бүрэн, үнэн зөв мэдээлж байхыг аймгийн ЗДТГ-ын холбогдох 4 мэргэжилтэнд сануулга өгсөн.	Зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна. Биелэлт 100 хувь.

	агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-3.1-т заасны дагуу тогтсон хугацаанд нь иж бүрэн, үнэн зөв мэдээлж байх.		
3	Хуулийн 3.1.4-т хамаарах аж ахуйн нэгжүүдийн шилэн дансанд байршуулах мэдээллийг аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны цахим хуудсанд батлагдсан маягтаар улирал бүр нэгтгэж, бүрэн мэдээлж байх.	Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагыг хуулийн хугацаанд бүрэн мэдээлүүлж байхыг ХОХБТХ-ийн мэргэжилтэнд үүрэг болгосон.	Зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна. Биелэлт 100 хувь.
4	Шилэн дансны тухай хуулийн 3.1.5-д заасан аж ахуйн нэгж, байгууллагуудад хуулийг хэрэгжүүлэх талаар сургалт явуулж, шилэн дансанд байршуулж буй мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллах.	Нийт төсвийн захирагч, нягтлан бодогч нарт "Шилэн дансны тухай" хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой сургалт хийхээр Санхүү, төрийн сангийн хэлтэс нь 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө оруулан, мэдээллийг үнэн зөв оруулах талаар өрхийн эмнэлэг, хувийн цэцэрлэгүүдэд мэдээлэл хүргэсэн.	Хувийн цэцэрлэгүүд үйл ажиллагаа явуулахтай холбоотой гарсан зардлыг мэдээлээгүй зөрчил арилаагүй байна. Биелэлт 30 хувь.
5	Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтыг мөрдүүлж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллах.	Санхүү, төрийн сангийн хэлтэс нь Санхүүгийн хяналт, аудитын албатай хамтран шилэн дансны зарчмыг мөрдүүлж, арга зүйгээр хангаж ажиллах талаар үр дүнгийн гэрээнд тусгасан.	Өгсөн зөвлөмжийн дагуу нийт байгууллагын нягтлан бодогч нарыг нэгдсэн арга зүйгээр хангаагүй, аймгийн Засаг даргын 127 тоот захирамжаар шилэн дансны мэдээлэлд хяналт тавьж ажилласан байдлыг аймгийн хэмжээнд нэгтгэж дүгнээгүй, үр дүнг тооцож ажиллаагүй байна. Биелэлт 30 хувь.
Санхүүгийн хяналт, аудитын албанд			
1	Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 8.1, 8.2 -т заасны дагуу дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж, тайланг холбогдох байгууллагад хүргүүлж ажиллах.	2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 213 тоот албан бичгээр Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2, 3 дугаар улиралд дотоод хяналт хийсэн тухай илтгэх хуудсыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлжээ. Мөн 2018 оны 4 дүгээр улирлын шилэн дансны мэдээлэлд хийсэн хяналт шалгалтын тайланг бэлтгэж, Сангийн яаманд хүргүүлсэн.	Зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна. Биелэлт 100 хувь.
2	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэхгүй болсон, татан буугдсан байгууллагуудыг Сангийн яаманд мэдэгдэж, шилэн дансны цэсийг цэгцлэх	Орог нуур-Түйн голын сав газрын захиргаа болон Заг сумын Эмийн эргэлтийн санг шилэн дансны системээс хассан, байгууллагын төрлийг өөрчилсөн зэргийн талаар Сангийн яамнаас хариу ирүүлсэн.	Зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна. Биелэлт 100 хувь.
БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ			76,3%

Аудитаар нийт 2395,1 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, үүнээс 243,7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2151,4 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлэв.

Өмнөх оны аудит болон 2018 оны 4 улирлыг хамруулсан энэ удаагийн нийцлийн аудитын дүнг нэгтгэвэл 2018 оны байдлаар шилэн дансны нэгдсэн хуудсанд байршуулсан мэдээллээс нийт 9758,4 сая төгрөгийн зөрчил илэрч, үүнээс 998,7 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 7761,0 сая төгрөгийн зөрчилд хууль, тогтоомжийг мөрдөж, зөрчлийг дахин гаргахгүй байх зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

Холбогдох байгууллагын санал



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

64101 Номгон, Баянхонгор сум
Вэбсайт: www.bayankhongor.gov.mn
Утас/Факс: (976) 70-44-22-73

2019.04.08 № 5/578
танай 2019.04.05 -ны № 1/200 -т

Г БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР Т

“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”- д хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Төсөлд өгөх санал хүсэлт байхгүй.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА С.БАЙГАЛМАА



1190734

D:\2019 он\Тамгын газар\Тамгын газар А5 тоот+.docx



БАЯНХОНГОР АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН
АЛБА

64101 Номгон, Баянхонгор сум
Утас 70-44-44-29

2019.04.08 № 52
танай 2019.04.05 -ны № 1/200 -Т

Г
БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд
хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлд
холбогдох санал байхгүй болно.

ДАРГА  Б.НАРМАНДАХ

2519034

Байгууллагуудаас санал ирээгүй болно.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна.

1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 хамаарах байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдаж, мэдээллийн 90.9 хувийг хугацаанд нь байршуулсан байгаа ч мэдээллийн агуулга, чанар хангалтгүй байна.
2. Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-т хамаарах аж ахуйн нэгж, байгууллагуудын хувьд дараа жил нь үйл ажиллагаа явуулах эсэх нь тодорхойгүй байхад цахим хуудаст шинээр цэс нээж мэдээлүүлэх нь хуулийн энэ заалт хэрэгжих боломжгүй байна.
3. Төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна.
4. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дах хэсэгт заасан байгууллага, албан тушаалтнууд мэдээллийг нарийвчлан хянадаггүйгээс мэдээллийн үнэн зөв байдал хангалтгүй, мэдээллийг давхардуулсан, орхигдуулсан байна.
5. Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.
6. Сумын ИТХ-ын төсөв баталсан тогтоол, Сум хөгжүүлэх сангийн болон ангилагдаагүй зардлаас санхүүжүүлж буй ЖДҮ-ийн төслийн сонгон шалгаруулалтын талаарх мэдээллийг иж бүрэн мэдээлээгүй, тодруулга өгөх албан тушаалтны мэдээллийг шинэчлээгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна.

НЭГ. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Г.БАТЖАРГАЛ ТАНАА

1. Аймгийн Засаг даргын 2017 оны 127 тоот захирамжийн дагуу шилэн дансны мэдээлэлд хяналт тавьж ажилласан байдлыг аймгийн хэмжээнд нэгтгэн дүгнэж, холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх
2. Аймаг, сумын төсөв баталсан тогтоол, Сум хөгжүүлэх сангийн болон ангилагдаагүй зардлаас санхүүжүүлж буй ЖДҮ-ийн төслийн сонгон шалгаруулалтын талаарх мэдээллийг шилэн дансны цахим цэсэнд иж бүрэн мэдээлэх
3. Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан “Заавар батлах тухай” тушаалын хавсралтын 2.2.15 дахь заалтыг хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах

**ХОЁР. САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН
АЛБАНЫ ДАРГА Б.НАРМАНДАХ ТАНАА**

1. Шилэн дансны нэгдсэн хуудсанд байршуулсан мэдээллийг нэг бүрчлэн анхан шатны баримтад үндэслэн тулган шалгаж, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтыг мөрдүүлж ажиллах.
2. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтын дагуу шилэн дансны нэгдсэн хуудсанд 2018 онд мөнгөн дүнг зөрүүтэй мэдээлсэн алдааг залруулуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, гарсан үр дүнгийн талаар 2019 оны 09 дүгээр сарын 10-ны дотор Баянхонгор аймгийн Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлэх